



2023 оны үйл ажиллагааны ТАЙЛАН

Ханбогд сумын Гурван талт зөвлөл



Ханбогд сум
2024 он

АГУУЛГА

МЭНДЧИЛГЭЭ	1
1-Р БҮЛЭГ. ЗАСАГЛАЛ	3
1.1 Зөвлөлийн удирдлага	3
1.2 Зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн	3
1.3 Зохион байгуулсан хурал, сургалт арга хэмжээ, ажлын хэсэг ...	5
1.4 Хараат бус хөндлөнгийн үнэлгээ, аудит	11
1.5 Мэдээллийн ил тод байдал	12
1.6 Санал хүсэлт, өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдал	12
2-Р БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ	13
2.1 Тайлант онд зөвлөлийн шийдвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ	13
2.1.1 Усжуулалт	13
2.1.2 Оюутны сургалтын тэтгэлэгт хөтөлбөр	16
2.1.3 Дундын хоршоо байгуулах ажил	16
2.2 Тогтвортой амьжиргааны төсөл хөтөлбөр	17
2.3 “Ундайн голын өв соёл” төсөл	21
2.4 Мониторинг	21



МЭНДЧИЛГЭЭ



Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж буйдаа баяртай байна.



Х.ОТГОНЖАРГАЛ

Гурван талт зөвлөлийн
ахлагч, Ханбогд сумын Засаг
даргын орлогч



С.ДОРЖДЭРЭМ

Гурван талт зөвлөлийн
удирдах нэгжийн гишүүн,
“Оюутолгой” ХХК-ийн орон
нутгийн харилцааны хэлтсийн
менежер



Ч.НАМНАНСҮРЭН

Гурван талт зөвлөлийн
удирдах нэгжийн гишүүн,
Ханбогд сумын Жавхлант
багийн малчдын төлөөлөл

Гурван талт зөвлөлийн талууд, гишүүд, малчид, хамтрагч байгууллагууд (Малчдын гомдол барагдуулах гэрээ-1, гэрээ-2)-ний хэрэгжилтийг хангахын төлөө тууштай хамтран ажиллалаа. Зөвлөлийн зүгээс 2023 онд “Малчдын гомдол барагдуулах гэрээ-1, гэрээ-2”-ийн хэрэгжилтийг хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгууллаа. Түүнчлэн зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг дотооддоо үнэлж, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн малчдын гомдол барагдуулах гэрээний биелэлтийг хангах хүрээнд 18 зорилт, арга хэмжээ бусад 11 зорилт, арга хэмжээ нийт 29 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр зөвлөлийн хурлаар хэлэлцэж баталлаа.

Тайлант онд зөвлөлийн санаачлагаар Оюутолгойн уурхайн Хаягдал хадгалах байгууламжид үүсээд байсан нөхцөл байдалтай уялдуулан нэгдсэн зөвлөгөөн зохион



байгуулж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөв. Зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах, иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх хүрээнд мэргэжлийн байгууллагын зөвлөгөө, сургалтад хамруулж, гишүүдээ чадавхжууллаа. Нутаг орны ирээдүй хойч болсон оюутан залуусыг дэмжих хүрээнд Оюутны сургалтын тэтгэлэгт хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлсэн бөгөөд хөтөлбөрийн шаардлагыг хангасан нийт 31 оюутны сургалтын төлбөрийн 50 хувийг “Оюутолгой” компанийн санхүүжилтээр шийдвэрлэсэн байна.

ГТЗ-ийн дүрэмд заасны дагуу хариуцлагатай, ёс зүйтэй, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, нам улс төрөөс ангид байх зарчмыг баримталж “ГТЗ-ийн гишүүдийн ашиг сонирхлын зөрчлийг удирдах журам”-ыг гишүүд маань мөрдлөг болгон ажиллалаа. Ирж буй 2024 онд ГТЗ-ийн нийт гишүүд (Малчдын гомдол барагдуулах гэрээ-1, гэрээ-2)-ний хэрэгжилтийг улам эрчимжүүлж, ёс зүйтэй, хариуцлагатай ажиллаж бидний хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн үр шим цаашид илүү олон хүнд хүрэх болно гэдэгт итгэлтэй байна. Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг бид хамтдаа бүтээнэ.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.



**БҮЛЭГ 1.****ЗАСАГЛАЛ****➤ 1.1 ЗӨВЛӨЛИЙН УДИРДЛАГА**

Гурван талт зөвлөлийн дүрэмд зааснаар Зөвлөлийн шийдвэрийг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэдэг. Түүнчлэн Зөвлөлийн тэргүүнээр талуудыг ахалж буй гишүүд жил бүрээр ээлжлэн ажиллах дүрмийн зохицуулалттай. Энэ дагуу 2023 оны 6 дугаар сараас эхлэн орон нутгийн Засаг захиргааны төлөөллийн ахлагч, Засаг даргын орлогч Х.Отгонжаргал зөвлөлийн даргаар ажиллаж байна. ГТЗ-ийн Удирдах нэгжийн бүрэлдэхүүнд Оюутолгой компанийн төлөөллийн ахлагч, Орон нутгийн харилцааны хэлтсийн менежер С.Дорждэрэм, Малчдын төлөөллийн ахлагч, Ханбогд сумын Жавхлант багийн малчдын төлөөлөл Ч.Намнансүрэн нар тус тус ажиллаж байна.

➤ 1.2 ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН**Орон нутгийн Засаг захиргааны төлөөлөл**

Х.Отгонжаргал
Ханбогд сумын Засаг
даргын орлогч



Б.Алтангэрэл
Ханбогд сумын ЗДТГ-
ын Уул уурхай, байгаль
орчин хариуцсан
мэргэжилтэн



Э.Жамбалсанжид
Ханбогд сумын
Жавхлант багийн Засаг
дарга



М.Мягмаржав
Ханбогд сумын Баян
багийн Засаг дарга



М.Сүглэгмаа
Ханбогд сумын Засаг
даргын Тамгын газрын
мэргэжилтэн



Малчдын төлөөлөл



Ч.Намнансүрэн Жавхлант багийн малчдын төлөөлөл

Б.Эрдэнэбаяр Жавхлант багийн малчдын төлөөлөл

Э.Сүрэнхорол Жавхлант багийн малчдын төлөөлөл

М.Батхүү Баян багийн малчдын төлөөлөл

Н.Одгэрэл Баян багийн малчдын төлөөлөл

Х.Энхбат Баян багийн малчдын төлөөлөл

Ц.Олонбаяр Номгон багийн малчдын төлөөлөл

Ч.Сувдаа Номгон багийн малчдын төлөөлөл

У.Гантөмөр Номгон багийн малчдын төлөөлөл

Б.Баярцэнгэл Гавилууд багийн малчдын төлөөлөл

Д.Эрдэнэцэцэг Гавилууд багийн малчдын төлөөлөл

Ц.Баттогтох Гавилууд багийн малчдын төлөөлөл



"Оюутолгой" ХХК-ийн төлөөлөл



С.Дорждэрэм
Орон нутгийн
харилцааны хэлтсийн
дэмжлэг, түншлэлийн
менежер



П.Золбуянхишиг
Орон нутгийн
харилцааны хэлтсийн
мэргэжилтэн



Л.Мөнх-Оргил
Уурхайн үйл ажиллагаа
хариуцсан ерөнхий
зөвлөх



Б.Ууганбаяр
Байгаль орчны хэлтсийн
ахлах мэргэжилтэн



Ж.Эрдэнэбилэг
Хөдөлмөрийн
харилцааны хэлтсийн
менежер

1.3 ЗОХИОН БАЙГУУЛСАН ХУРАЛ, СУРГАЛТ АРГА ХЭМЖЭЭ, АЖЛЫН ХЭСЭГ

Гурван талт зөвлөлийн хурал

Гурван талт зөвлөлийн дүрэмд заасны дагуу тайлант онд Гурван талт зөвлөлийн хурлыг бүх гишүүдийн оролцоотойгоор 3, 5, 7, 9, 11 дүгээр саруудад нийт 5 удаа зохион байгуулав.





Удирдах нэгжийн хурал, Малчдын төлөөллийн уулзалт



Гурван талт зөвлөлийн Удирдах нэгж 2023 онд нийт 11 удаагийн хамтын уулзалт, хурал хийв. Эдгээр хурал, уулзалтаар цаг үеийн асуудлыг хэлэлцэхээс гадна хэрэгжилт удааширч буй төсөл арга хэмжээний биелэлтийг эрчимжүүлэх, ГТЗ-ийн ээлжит хурлын тов тогтоох, хурлаар хэлэлцэх асуудал, хөтөлбөр бэлтгэх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Малчдын төлөөлөл 6 удаагийн уулзалт хийж, ГТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх асуудал болон малчдад тулгамдаж буй асуудлаар ярилцав.

Ажлын хэсгүүд, бүтэц, чиг үүрэг

ГТЗ-ийн зүгээс хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр болон малчдын гомдол барагдуулах гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор дараах ажлын хэсгүүдийг байгуулж, тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд ажлын хэсгүүд нийт 14 удаа хуралдсан.

№	Чиг үүрэг	Бүрэлдэхүүн
1	Малчдын гүн өрмийн худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийн тоног төхөөрөмж суурилуулах ажлыг цаашид ямар хугацаанд, жил бүр тодорхой хэмжээний квот тогтоож, ямар шалгуур үзүүлэлтийн дагуу хэрэгжүүлэх боломжийг судлах ажлын хэсгийн бүрэлдэхүүн	Оюу толгой компани: Б.Баярбаатар ОНЗЗ: Э.Жамбалсанжид, М.Мягмаржав, У.Гантөмөр
2	Манлай-Оюутолгой чиглэлийн сайжруулсан шороон замын одоогийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, нөхөн сэргээлтийн төлөвлөлт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн 1. Төлөгийн талын биологийн нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөгөөний дагуу үргэлжлүүлэх 2. Төлөгийн талаас гадна нөхөн сэргээлт хийх байршил малчдаас санал авч эцэслэх (Салаалж байгаа уулзварыг нэн тэргүүнд нөхөн сэргээх) 3. Цаашид зам засварын ажил, үргэлжлэх хугацаа болон бусад мэдээллийг ОТ-с эргэн мэдээлэх	Ажлын хэсгийн ахлагч: Б.Алтангэрэл (ОНЗЗ-ны төлөөлөл) Б.Баярцэнгэл (Малчдын төлөөлөл) Ц.Баттогтох (Малчдын төлөөлөл) Д.Эрдэнэцэцэг (Малчдын төлөөлөл) М.Сүглэгмаа (ЗДТГ-ын мэргэжилтэн)
3	Оюутолгой-Ханбогд чиглэлийн автозамын хог цэвэрлэгээ, Оюу Толгой-Дэлийн бууц чиглэлийн сайжруулсан шороон замын байнгын усалгаа хийх ажлуудад тухайн ойр орчмын малчин өрхийг оролцуулахад дэмжлэг үзүүлэх, урьдчилсан судалгаа хийх, шалгуур үзүүлэлтийн хувилбар боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн:	Ажлын хэсгийн ахлагч: Э.Жамбалсанжид П.Золбуянхишиг, Б.Ууганбаяр (ОТ компанийн төлөөлөл) Б.Алтангэрэл (ОНЗЗ-ны төлөөлөл) Ч.Намнансүрэн, Б.Эрдэнэбаяр, Д.Эрдэнэцэцэг (Малчдын төлөөлөл)
4	"Ундайн голын өв соёл" төслийг хэрэгжүүлэхэд мөрдөж ажиллах журам боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн	Ажлын хэсгийн ахлагч: Б.Батзориг (ОТ компанийн төлөөлөл) Э.Жамбалсанжид (ОНЗЗ-ны төлөөлөл) Ч.Намнансүрэн (Малчдын төлөөлөл)



№	Чиг үүрэг	Бүрэлдэхүүн
5	Дундын хоршоо байгуулах ажилд тулгамдаж буй асуудлыг судлах, шийдвэрлэх хувилбар арга зам боловсруулах, тулгамдаж буй асуудлыг судалж, холбогдох арга хэмжээг зохион байгуулах, зөвлөлийн гишүүдийг мэдээллээр хангах (Мал нядалгааны шугам барих, байнгын ажиллагаатай болох) ажлын хэсгийн бүрэлдэхүүн	Ажлын хэсгийн ахлагч: Б.Эрдэнэбаяр (МТ) Х.Энхбат (МТ) Б.Баярцэнгэл (МТ) Ц.Баттогтох (МТ)
6	Мал аж ахуйн 10 жилийн хөтөлбөрт туссан төсөл сонгон шалгаруулах журам, шалгуур үзүүлэлт, сэдэв болон холбогдох бусад бэлтгэл ажил зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн	Ажлын хэсгийн ахлагч: Х.Отгонжаргал (ОНЗЗ) М.Сүглэгмаа (ОНЗЗ) Л.Баярбаатар (ОТ) П.Золбуянхишиг (ОТ) Б.Эрдэнэбаяр (МТ) Ч.Намнансүрэн (МТ) Ц.Баттогтох (МТ) У.Гантөмөр (МТ) Э.Сүрэнхорол (МТ)
7	Усны менежментийн асуудлаар нэгдсэн хурал зохион байгуулах бэлтгэл ажил хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн	Ажлын хэсгийн ахлагч: Б.Алтангэрэл (ОНЗЗ-ны төлөөлөл) Б.Ууганбаяр (ОТ компанийн төлөөлөл) Х.Энхбат (Малчдын төлөөлөл)
8	Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн шийдвэр, Оюутолгой компанийн санхүүжилтээр 2023-2024, 2024-2025 оны хичээлийн жилүүдэд магадлан итгэмжлэгдсэн дотоодын их, дээд сургуулийн бакалаврын түвшинд суралцаж байгаа Ханбогд сумын малчин өрхийн оюутанд сургалтын төлбөрийн 50 хувийн тэтгэлэг олгох ажлын хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн	Ажлын хэсгийн ахлагч: Э.Жамбалсанжид (Жавхлант багийн Засаг дарга) М.Мягмаржав (Баян багийн Засаг дарга) Ж.Эрдэнэбилэг (Оюу Толгой компанийн Хүний нөөцийн хэлтсийн менежер) Б.Ууганбаяр (Оюу Толгой компанийн Байгаль орчны хэлтсийн ахлах мэргэжилтэн) Ц.Баттогтох (Гавилууд багийн Малчдын төлөөлөл) Х.Энхбат (Баян багийн Малчдын төлөөлөл) Н.Одгэрэл (Баян багийн Малчдын төлөөлөл)
9	Ногоон тэжээлийн ургамал тариалах судалгааны ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Б.Алтангэрэл (ОНЗЗ-ны төлөөлөл) М.Сүглэгмаа (ОНЗЗ-ны төлөөлөл) М.Мягмаржав (ОНЗЗ-ны төлөөлөл) Б.Баярбаатар (Оюу толгой компанийн төлөөлөл) Ц.Баттогтох (Малчдын төлөөлөл) М.Батхүү (Малчдын төлөөлөл) Х.Энхбат (Малчдын төлөөлөл) Ц.Олонбаяр (Малчдын төлөөлөл)



№	Чиг үүрэг	Бүрэлдэхүүн
10	Гадаад улсад туршлага судлах, Гишүүдийг чадавхижуулах сургалтыг зохион байгуулах санал, хувилбар боловсруулах ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: Д.Ууганбаяр (Хараат бус нарийн бичгийн ажилтан) М.Мягмаржав (ОНЗЗ-ны төлөөлөл) Б.Ууганбаяр (Оюу толгой компанийн төлөөлөл) Д.Эрдэнэцэцэг (Малчдын төлөөлөл)
11	Зорилтот бүлгийн нэрсийн жагсаалт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: П. Золбуянхишиг (Оюу толгой компанийн төлөөлөл) Ч.Намнансүрэн (Малчдын төлөөлөл) Б. Батзориг (Оюу толгой компанийн төлөөлөл) М.Мягмаржав (ОНЗЗ-ны төлөөлөл)
12	Хаягдал хадгалах байгууламжийн одоогийн нөхцөл байдалд хөндлөнгийн аудитын байгууллагаар үнэлгээ хийлгэх ажлын даалгаварын төсөл боловсруулах, явцын мэдээлэл танилцуулах	Ажлын хэсгийн ахлагч: Б.Алтангэрэл ОНЗЗ: Э.Жамбалсанжид, О.Ангараг Оюу Толгой компани: С.Дорждэрэм, Б.Ууганбаяр, С.Тамир Малчдын төлөөлөл: Б.Эрдэнэбаяр, Н.Ширнэн, Ж.Батсүлд, Б.Шинэбаяр Мөнх ногоон Галба: Б.Буянтогтох ИТХ-ын УУБОХХ-ийн хороо: Л.Болорцэцэг Мэргэжлийн судлаач: Н.Наранцогт

“Оюу Толгой уурхайн хүдрийн хаягдлын сангийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцох зөвлөгөөнд оролцов.

Ханбогд сумын Гурван талт зөвлөл Оюу толгой уурхайн хаягдлын сангийн бүтэц зохион байгуулалт болон үйл ажиллагаатай танилцаж, түүний Байгаль орчин болон Эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг хэрхэн олон улсын арга аргачлалд нийцүүлэх талаар туршлага солилцох арга хэмжээ 2023 оны 07 сарын 25, 26-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа.



Уг арга хэмжээнд

- Монгол Улсын Их Сургууль
- Монгол Улсын Боловсролын Их Сургууль
- Ханбогд сумын ИТХ-ийн Байгаль Орчин Уул Уурхай, Хөдөөгийн хөгжлийн хороо
- “Ханлаб” лаборатори
- “Оюу Толгой Хяналт” ТББ
- “Говийн Газар Шороо” ТББ
- “Мөнх Ногоон Галба” ТББ
- ГТЗ-ийн Малчдын зөвлөх Аккаунтибилити коунсил ТББ
- Жавхлант багийн малчид
- Оюу Толгой компанийн Байгаль орчин, Хаягдлын далангийн хэлтэс, Орон нутгийн хэлтэс, бусад холбогдох байгууллагын төлөөллүүд оролцож, мэргэжлийн зөвлөгөө зөвлөмж өгч, практик туршлагаас хуваалцсан юм.

Зөвлөгөөний үеэр төлөөллүүд Оюу Толгой уурхайн Баяжуулах үйлдвэр, Ил уурхайн үйл ажиллагаа, Хаягдлын сангийн нөхцөл байдалтай танилцаж, цаашид анхаарах шаардлагатай асуудлын талаар байр сууриа илэрхийлж, санал солилцсон бөгөөд Хаягдлын сангийн одоогийн нөхцөл байдалд олон талт хөндлөнгийн мэргэжлийн шинжээчдийн багаар үнэлгээг хийлгэж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхөөр талууд тохиров.

Чадавхжуулах сургалтад хамрагдав

Зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “ГТЗ-ийн гишүүдийг чадавхжуулах сургалт”-ыг хараат бус нарийн бичгийн газраас хариуцан 2023 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотод зохион байгууллаа. Хувь хүнийг хөгжүүлэх, мэргэшүүлэх, хамтын ажиллагаа, тэгш оролцоог хэрхэн үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр “Гурван талт зөвлөлийн гишүүний манлайлал, ур чадвар, харилцааны соёл”, “Хурал, зөвлөгөөнд идэвхтэй оролцож, удирдан чиглүүлэх нь” сэдвийн хүрээнд SFRS төслийн удирдагч Олон улсын сургагч багш Ч.Амартунгалаг, Нийгмийн сүлжээний орчинд баримт нягтлах арга зүй сэдвээр МУИС, Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхмийн багш Б.Түвшинтөр зэрэг сургагч багш нар мэдээллээр хангав.



Сүүлийн жилүүдэд хамгийн ихээр хөндөгдөх болсон усны асуудал, тэр дундаа Говь руу ус татах талаар нарийвчилсан мэдээлэлтэй болох зорилгоор Усны газар, Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, бороошуулах төхөөрөмжийн талаар “Нар хур трейд” ХХК-ын төлөөллийг оролцуулж, мэдээлэл авч, санал солилцлоо.

Түүнчлэн Өмнөговь аймгийн болон Ханбогд сумын хөдөө, аж ахуйн бодлого чиглэл, цаашдын чиг хандлага, хоршооны засаглал, үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг чиглэлээр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо болон холбогдох бусад төрийн болон төрийн бус байгууллагууд оролцож зөвлөлийн гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангасан юм.



“Малчин өрхийн оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийн батламж гардууллаа

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн санаачлага, Оюутолгой компанийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Малчин өрхийн оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийн батламж гардуулах арга хэмжээг 2023 оны 11 сарын 03-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулав.

Арга хэмжээний үеэр тэтгэлэгт хөтөлбөрийн шаардлага хангасан Ханбогд сумын малчин өрхийн нийт 31 оюутан батламж гардан авсан юм.

“Малчин өрхийн оюутны тэтгэлэгт хөтөлбөр” нь Гурван талт зөвлөлийн зүгээс санаачлан хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөрийн нэг бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилд дотоодын их, дээд сургуульд суралцаж буй Ханбогд сумын малчин өрхийн оюутнуудад мэргэжил болон курс харгалзахгүйгээр сургалтын төлбөрийн 50 хувийг Оюутолгой компаниас санхүүжүүлэн олгож байгаагаараа онцлог юм.



Тус хөтөлбөр нь дотоодын их, дээд сургуульд суралцаж буй оюутан залууст сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлж, орон нутгийн шилжилт хөдөлгөөнийг бууруулах, ажиллах боловсон хүчнийг аймаг, сумандаа ирж ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлэх бодлого төлөвлөгөөтэй уялдсан томоохон хөрөнгө оруулалт болно гэж харж байгаа юм. Хөтөлбөрийг 2024-2025 оны хичээлийн жилд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Багуудын иргэдийн Нийтийн хуралд оролцож мэдээлэл хүргэв

Ханбогд сумын багуудын иргэдийн Нийтийн Хурал 2023 оны 09 сарын 22-ны өдөр Ханбогд сумын Соёлын төвд зохион байгуулагдсан бөгөөд зөвлөлийн хараат бус нарийн бичгийн байгууллагын зүгээс хуралд оролцож, ГТЗ-өөс 2023 онд хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний талаар иргэдэд мэдээлэл хүргэж, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудыг танилцуулав.



Малын эмч нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулав.

Зөвлөлийн дэмжлэгтэйгээр “Оюутолгой” ХХК-ийн санхүүжилтээр Ханбогд суманд эпидемиологи, тархвар зүй, гоц халдвартын эрт илрүүлгийн сургалтыг 15 сумдын 40 эмч мэргэжилтэнийг хамруулан зохион байгуулав.



➤ 1.4 ХАРААТ БУС ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ, АУДИТ

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн (Малчдын гомдол барагдуулах гэрээ-1, гэрээ-2)-нд заасан Гомдлыг шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэхээр тохирсон арга хэмжээ буюу хийхээр тохирсон ажлын хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийж, үйл ажиллагаа бүрийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох, үнэлгээнд тулгуурлан сайжруулах ажлын төлөвлөлт хийх зорилгоор (Малчдын гомдол барагдуулах гэрээ-1, гэрээ-2)-ний хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлын гүйцэтгэгчээр “Сика” судалгааны байгууллага шалгарсан бөгөөд хөндлөнгийн үнэлгээний ажлын тайланг 2023 онд багтаан зөвлөлд хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Зөвлөлийн хувьд хөндлөнгийн үнэлгээний үр дүн, санал зөвлөмжид тулгуурлан цаашид ажиллах төлөвлөлт, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тооцоолох боломжтой болох юм.

ГТЗ-ийн (Малчдын гомдол барагдуулах гэрээ-1, гэрээ-2)-нд заасан зорилт арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлж байгаад зөвлөлийн зүгээс дотоод хяналт үнэлгээг тогтмол хийж байгаа бөгөөд 2023 оны 11 сард ГТЗ-ийн ээлжит хэлэлцэн зохион байгууллаа.

Оюутолгой компанийн 2011 оны Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хаалтын аудитын ажлыг хийж гүйцэтгэх байгууллагаар Sustainability East Asia ХХК, IRIM Судалгааны хүрээлэн хамтарсан концерциум 2023 оны 6-р сард шалгаран хөндлөнгийн үнэлгээний ажлыг гүйцэтгэж байна.

Хаалтын аудитын үр дүнд Оюу Толгой компанийн амлалт, үйл ажиллагаа зохих ёсоор биелж, үр дүнд хүрсэн эсэхийг тодорхойлох боломжтой юм.

Өрхийн хөөн хэлэлцэх нөхөн олговор олгох ажил хамгийн өндөр гүйцэтгэлтэй буюу 95.1% байна. Харин нийтийн нөхөн олговрын хүрээнд тохирсон ажлын



хэрэгжилт хамгийн доогуур буюу 41%-ийн гүйцэтгэлтэй байна. Хавсралт 1-д гэрээний хэрэгжилтийн үнэлгээг хүснэгтээр үзүүлээ.

ГТЗ-ийн засаглалын хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагаар хараат бус үнэлгээ хийлгэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах шатандаа явагдаж байна.

➤ 1.5 МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

ГТЗ-ийн үйл ажиллагааны мэдээ мэдээллийг ГТЗ-ийн <http://tpc.mn/> цахим хуудас, зөвлөлийн албан ёсны (<https://www.facebook.com/TripartiteCouncilB>) фейсбүүк хуудсаар тогтмол хүргэж байна. Мөн ГТЗ-ийн албан ёсны и-мэйл (tripartitecouncil.kb@gmail.com) хаягийг ГТЗ-ийн нарийн бичгийн ажилтан хариуцан ажиллаж байна.

Түүнчлэн мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр 2023 оны арванхоёрдугаар сард Ханбогд сумын 4 багийн малчдыг төлөөлсөн гишүүдээр дамжуулан ГТЗ-өөс хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээ болон цаг үеийн мэдээллийг хэвлэмэл тайлан хэлбэрээр бэлтгэн, малчин өрх, сонирхогч талуудад хүргүүлэв.

➤ 1.6 САНАЛ ХҮСЭЛТ, ӨРГӨДӨЛ ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

2023 онд ГТЗ-д хандан, орон нутгийн 4 аж ахуйн нэгж, иргэнээс хүсэлт ирүүлснийг ээлжит хурлаар хэлэлцэж, хариуг нь хүргүүлэв.



БҮЛЭГ 2.

ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн талууд болох Ханбогд сумын Засаг захиргаа, Ханбогд сумын малчид, “Оюутолгой” компани хамтран 2017 оны 5 дугаар сарын 9-нд Малчдын гомдол барагдуулах хоёр багц гэрээг байгуулсан билээ. Энэхүү хоёр гэрээнд Бэлчээр, Ус, Нөхөн олговор, Ундай гол зэрэг дэд сэдвийн хүрээнд нийт 64 асуудлыг шийдвэрлэхээр тусгасан юм. 2023 онд гэрээний хэрэгжилтийг үнэлж үзэхэд (Малчдын гомдол барагдуулах гэрээ-1, гэрээ-2)-нд тусгагдсан нийт 64 ажлаас 26 ажил бүрэн хэрэгжиж дууссан байна. Бүрэн хэрэгжсэн ажлуудаас ач холбогдол, үр ашгийг нь харгалзан үзсэний үндсэн дээр зарим ажлыг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаад байна.



➤ 2.1 2023 ОНД ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭРЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

2.1.1 Усжуулалт

Ханбогд сумын “Гурван талт зөвлөл”-ийн малчдын гомдлыг барагдуулах гэрээгээр хэрэгжүүлэхээр тохирсон ажлын хүрээнд эвдэрч муудсан худгуудыг сэргээн завсарлах, бүрэн тоноглогдсон сувагчилтай худаг шинээр гаргах, малчдын гүн өрмийн худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийн тоног төхөөрөмж суурилуулах ажлыг гүйцэтгэж байна. Засварлах болон шинээр гаргах, нарны панел суурилуулах худгийг сонгохдоо Ханбогд сумын багийн иргэдийн нийтийн хурал, Зөвлөлийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн сонгож байгаа. Ажлын гүйцэтгэлийг Сумын Засаг даргын Тамгын газраас томилогдсон ажлын хэсэг хянаж хүлээн авдаг. Ингэхдээ худаг эзэмшигч малчдыг байлцуулан, гүйцэтгэлийн чанарт саналыг нь тусган ажиллаж байна.



2017 оноос худаг, усны нөхцөл сайжруулах чиглэлээр хийсэн ажлын дүн

№	Хэрэгжсэн он	Хүдгийн тоо	Санхүүжүүлэгч
1	2019	16 гар худаг	Худаг эзэмшигч, Оюутолгой ХХК
2	2020	20 гар худаг	Оюутолгой ХХК
3	2021	20 гар худаг	Оюутолгой ХХК
4	2022	16 гар худаг, 4 туршилтын худаг	Оюутолгой ХХК
5	2023	8 гар худаг, 16 туршилтын худаг	Оюутолгой ХХК
Нийт дүн		80 гар худаг, 20 туршилтын худаг	

2.1.1.1 Малчдын гүн өрмийн худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийн тоног төхөөрөмж суурилуулах ажил

Гурван талт зөвлөлийн шийдвэрээр хэрэгжиж буй төслүүдийн нэг нь бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор “Малчдын гүн өрмийн худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийн тоног төхөөрөмж суурилуулах ажил” юм.

Уг ажлыг орон нутгийн “Батсэтгэл” ХХК гүйцэтгэсэн бөгөөд Ханбогд сумын 4 багийн нутаг дэвсгэрт нийт 20 гүн өрмийн худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийн тоног төхөөрөмж суурилуулав. Зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд уг ажлыг үргэлжүүлэн хэрэгжүүлэхээр тусгагдсан болно.



Нарны толь суурилуулах ажил

№	Хэрэгжсэн он	Худгийн тоо	Санхүүжүүлэгч
1	2017	10	Худаг эзэмшигч, Оюутолгой ХХК
2	2022	22	Оюутолгой ХХК
3	2023	20	Оюутолгой ХХК
Нийт дүн		52	-

2.1.1.2 Малчдын гар худаг сэргээн засварлах ажил

Ханбогд сумын “Гурван талт зөвлөл”-ийн малчдын гомдлыг барагдуулах гэрээгээр хэрэгжүүлэхээр тохирсон ажлын хүрээнд хуучин эвдэрч муудсан худгууд болон зун намрын отрын бүсийг усжуулах зорилгоор малчдын гар худгийг сэргээн завсарлах ажлыг 2019 оноос хийж гүйцэтгэж байна. Засварлах худгийг сонгохдоо Ханбогд сумын багуудын иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэж, баг тус бүрээс 2 гар худаг, 2023 онд нийт 8 гар худгийг засварлаж байна. 2019 оноос хойш өнөөдрийг хүртэл нийт 80 гар худгийг сэргээн засварлаад байна. Гар



худаг засварын ажлыг гүйцэтгүүлэхээр “Оюутолгой” компаниас орон нутагт тендер зарласан бөгөөд гүйцэтгэгчээр “Ботгон хөөвөр” орон нутгийн компани шалгарч, ажлыг гүйцэтгэсэн байна. Ханбогд сумын Засаг даргын Тамгын газраас томилогдсон ажлын хэсэг худгуудыг хүлээж авахдаа худаг эзэмшигч малчдыг байлцуулан, гүйцэтгэлийн чанарт тэдний саналыг тусгаж ажиллав.





2.1.1.3 Бүрэн тоноглогдсон сувагчилтай худгийн ажил

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн шийдвэрээр хэрэгжүүлж буй ажлуудын нэг нь худгийн ундаргыг нэмэгдүүлэх, үерийн хүчтэй урсгалд худгийн ам дарагдахаас сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж буй сувагчилтай худгийн ажил юм. 2023 оны байдлаар зөвлөлийн зүгээс санаачлан нийт 18 худгийг сувагчилтай хэлбэрээр засварласан байна.



2.1.1.4 Гүний худгийн байшин барих ажил

2023 онд худгийн байшин барих ажил амжилттай хэрэгжиж, 5 худгийн байшинг шинээр барьж, ашиглалтад оруулав.

2.1.2 Оюутны сургалтын тэтгэлэгт хөтөлбөр

Хэрэгжүүлэгч: Гурван талт зөвлөл

Хамрагдсан оюутны тоо: 31

Төсөл хэрэгжсэн газар: Өмнөговь аймаг

Ханбогд сум

Төсөл хэрэгжсэн хугацаа: 2023 оны 11 дүгээр сар

Гурван талт зөвлөлийн нийт гишүүдийн Ханбогд сумын малчин өрхүүдэд хүртээмжтэй байдлаар нийтийн нөхөн олговор олгох үүднээс 2023-2024 оны хичээлийн жилд дотоодын их дээд сургуульд суралцаж буй малчин өрхийн оюутнуудад дараах шалгуурын дагуу сургалтын тэтгэлэг олгох нэг удаагийн ажлыг зохион байгуулав.



- Ханбогд сумын малчин өрхийн хүүхэд байх;
- Сурлагын голч оноо 2.8 ба түүнээс дээш байх;
- Дотоодын их, дээд сургуульд шинээр элсэн орж байгаа суралцагчийн хувьд ЭЕШ-ын оноо 480 ба түүнээс дээш байх;
- Магадлан итгэмжлэгдсэн дотоодын их, дээд сургуулийн бакалаврын түвшинд суралцдаг байх;
- Нийгэм, олон нийтийн арга хэмжээнд идэвхитэй оролцдог байх (Залуусын хөгжлийн хөтөлбөр г.м)

2.1.3 Дундын хоршоо байгуулах ажил

Гурван талт зөвлөлийн санаачлагаар (Малчдын гомдол барагдуулах гэрээ-1, гэрээ-2)-ын хавсралтад тусгагдсан төслүүдийг хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах хүрээнд хөдөө аж ахуйн 4 багийн Дундын хоршоог байгуулахаар шийдвэрлэсэн билээ.

Уг зорилтын хүрээнд дундын хоршоо байгуулах зорилгоор баг тус бүрийн анхан шатны хоршоод хуралдан дундын хоршооны удирдлага, зохион байгуулалтын талаар хэлэлцэж, улсын бүртгэлийн байгууллагад албан ёсоор бүртгүүлж, дундын хоршооны даргаар Б.Дэндэвсамбыг томилсон байна. Дундын хоршоо нь цаашид малчны зах, мал нядалгааны зам төслүүд болон хөдөө аж ахуйн 10 жилийн

хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих Эрчимжсэн махны үхрийн ферм байгуулах төсөл болон Ногоон тэжээлийн ургамал тариалах төслүүдийн удирдлага менежментийг хариуцан ажиллах юм.

➤ 2.2 ТОГТВОРТОЙ АМЬЖИРГААНЫ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

Оюу Толгой компани 2011 онд Нөхөн олговрын хөтөлбөрт хамрагдсан 89 өрхтэй байгуулсан 5 жилийн гэрээний хугацаа дуусгавар болсон ба тэдгээр өрхүүдийн тогтвортой амьжиргааг хадгалах, бий болгох зорилгоор “Амьжиргааг дэмжих сургалтын хөтөлбөр”-ийг 2018 онд Оюу Толгой компаниас санхүүжүүлэн 1 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн. Хөтөлбөрт нөхөн олговор, нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан нийт 89 өрхийн төлөөлөл 1 жилийн хугацаанд сургалтад хамрагдан, тэтгэлэг хүртэж, цаашид амьжиргаагаа тогтвортой авч явах боломжийг бүрдүүлэхээр ажилласан.

Хөтөлбөрийг 12 сарын хугацаатай дараах мэргэжлийн чиглэлээр зохион байгуулсан.

1. Мал аж ахуй
2. Газар тариалан
3. Оёдол
4. Бизнес
5. Гагнуур

Сургалтад хамрагдсан өрхийн гишүүд өөрсдийн санал санаачлагад тулгуурлан дараах төслүүдийг санаачлан хэрэгжүүлж байна. Хоршоодын үйл ажиллагааг сайжруулах, тогтворжуулах зорилгоор бизнесийн зөвлөх үйлчилгээг Хөгжлийн шийдэл ТББ ажиллаж байгаа. 2018–2023 он хүртэл 5 жилийн стратеги төлөвлөгөөгөө Хөгжлийн шийдэл бизнесийн зөвлөх байгууллагын тусламжтайгаар боловсруулж хэрэгжүүлсэн. Оюутолгой компанийн зүгээс төслүүдийн анхан шатны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулан нийт 1,5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Газар тариалангийн төсөл (Энергийн ундарга хоршоо)

2019 онд 9 малчин өрх нэгдэж “Энергийн ундарга” хоршоог байгуулан, бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байна.

“Энергийн ундарга” хоршооны гишүүд өргөст хэмх, улаан лооль зэрэг нарийн ногоог хоршооны 4 хүлэмжид, төмс хүнсний ногоог 2 га ил талбайд тариалж байгаа бо, хоршооны 1 гишүүн өвөлжөөнийхөө дэргэд тэжээлийн ургамал, эрдэнэшиш, төмс хүнсний ногоо тариалж байна.

Тариалсан ургацаа орон нутгийн дэлгүүр болон “Оюутолгой” компанид нийлүүлж, борлуулдаг. 2022 онд хоршооны хүсэлтээр “Оюутолгой” компаниас шаардлагатай 18.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг олгосон. Уг санхүүжилтээр 1 га талбайгаа нэмж хагалж усалгааны иж бүрэн систем суурилуулан, жилийн хугацаатай мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авсан байна. Мэргэжлийн зөвлөх авснаар Ханбогд суманд хүнсний ногооны аж ахуйг ил талбайн тариалалт болон хамгаалагдсан хөрсний аж ахуйг зэрэгцүүлэн хөгжүүлэх, ургамлын тариалалтын үе шатнаас эхлээд арчилгаа, хамгаалалт, ургац хураах хүртэлх бүхий л дамжлагын талаар мэдлэг мэдээлэлтэй болж байна.



Оёдлын төсөл ("Говь хан уран" ХХК)

Оёдлын сургалтад хамрагдсан 12 малчин эмэгтэй орлогын нэмэлт эх үүсвэртэй



болох хүсэл сонирхлоороо нэгдэж, өөрсдийн санаачилгаар 2017 онд "Говь хан уран" компанийг байгуулсан билээ. Тус компанид "Оюутолгой" компаниас санхүүжилт олгосон байна. Мөн бизнес менежментийн зөвлөхүүд, ижил төстэй бизнес эрхлэгчид, "Оюутолгой" ХХК-ийн Хангамжийн хэлтэс ба бусад боломжит худалдан авагчидтай холбож өгснөөр оёдлын үйлдвэрийн үйл ажиллагаа тогтворжиж, дараах амжилтыг гаргаад байна.

- Ханбогд суман дахь Залуучууд хөгжлийн төвийн гарааны бизнесийн хөтөлбөрт хамрагдаж, гуравдугаар байрт шалгарснаар нэмэлт сургалт авах, үйл ажиллагаа эхлүүлэх боломжтой болов.
- 2018 онд "Оюутолгой" компанид хөдөлмөр хамгааллын хувцас болон баяжмалын дээжийн уут нийлүүлэх гэрээ зурснаар байнгын ажилтай болж, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлсэн.
- 2019 онд Колумби улсад зохиогдсон дэлхийн 70 гаруй улсын залуу бизнес эрхлэгчдийн чуулганд оролцсон. Мөн үеэр оёдлын компанийн бизнесийн хурдацтай өсөлт, амжилтаараа нэр дэвшин өрсөлдөж, олон улсын оны шилдэг залуу бизнес эрхлэгчээр шалгарсан.

2023 оны байдлаар 4 ажилтантай, 15 тоног төхөөрөмжтэй үйл ажиллагаа явуулж, Оюу Толгой ХХК-д коврол, туг, кабелийн ханцуйвч гэрээгээр нийлүүлж байна

Ангус үхэр үржүүлэх төсөл ("Үнээгийн говь хоршоо")

"Үнээгийн говь" хоршоо нь цэвэр цусны Ангус үүлдрийн шинж чанарыг хангасан, говийн нөхцөлд бэлчээрт амьдарч дассан үхэртэй болох, олон улсын зах зээлийн шаардлагыг хангасан мах бэлтгэх зорилгоор 2018 онд байгуулагдсан, 15 гишүүнтэй, Ханбогд суманд үйл ажиллагаа явуулдаг махны чиглэлийн ангус үхэр үржүүлгийн аж ахуй юм.

Цэвэр үйлдвэрийн ангус бухаа говь нутгийн үхэрт эрлийзжүүлэн махны чиглэлийн үхэр өсгөх үржүүлэх мал аж ахуйн бизнес эрхэлдэг Ханбогд сумын анхны хоршоо болсон. Үнээгийн говь хоршоо нь байгуулагдсан цагаас эхлэн үйл ажиллагаа өргөжүүлэхийн зэрэгцээ, нийгмийн хариуцлагынхаа хүрээнд Ханбогд суманд "Мал угаалгын ванн" барин нутгийн малчдад тулгамдсан асуудлыг шийдэж өгсөн.



Махны чиглэлийн Гавилууд омгийн хонины аж ахуй эрхлэх төсөл (Гавилууд шилмэл сүрэг хоршоо)

“Гавилууд шилмэл сүрэг” хоршоог 2019 онд 13 өрх байгуулсан юм. Хоршооны дарга болон гишүүд ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй хоршоодоос туршлага судлах 5 удаагийн сургалт, арга хэмжээнд хамрагдсан байна. Төслийн хүрээнд хонины арьс нэхий боловсруулах цехийн барилгыг барьж, тоног төхөөрөмж суурилуулаад байна.



1. Малын тэжээлийн ургамлын тариалалт, дарш бэлтгэх технологи
2. Хоршоог чадавхижуулах, хоршоог сонсох уулзалт-ХАА яам, БО яам
3. Өмнөговь аймгийн хоршоодын гишүүд мэргэжилтэнүүдийг чадавхижуулах
4. Хонины ноосны чанар сайжруулах, цахилгаан хайчаар хонь хяргах сургалт
5. Хүнс хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтэнүүдийн зөвлөгөөн

Гавилууд омгийн хонины үүлдэр нь 2021 онд Гавилууд хэвшил омог болж батлагдсан юм. Гавилууд омгийн хонь дунджаар 5.3-7.8 хувийн илүү жинтэй. Энэхүү үзүүлэлтээрээ улсын хэмжээнд 4 дүгээрт орж байна.

Гахайн аж ахуй эрхлэх төсөл

Гахайн аж ахуй эрхлэх төслийг орон нутгийн 6 малчин өрх санаачилан “Гавилууд Гурван Шаваг” ХХК байгуулсан. 2023 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр фермийн шинэ байрны нээлтийн үйл ажиллагаагаа хийж шинэ байрандаа нүүж оров. Оюу Толгой ХХК-аас Малчдын Амьжиргаа Дэмжих Төслийн хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд суманд Эрчимжсэн гахайн аж ахуйн төсөлд санхүүжилтийн дэмжлэг үзүүлэв.

Гахайн аж ахуйн төсөл нь Ханбогд сумын хоолны газар, ресторанууд, уул уурхайн компаниудад сайн чанарын гахайн махыг үйлдвэрийн аргаар бэлтгэн нийлүүлэх зорилготой. Тус аж ахуйн сүргийн эргэлт 100 гахай бөгөөд жилдээ дунджаар 10 тонн гахайн махыг зах зээлд бэлтгэн нийлүүлэх хүчин чадалтай төсөл юм.





Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт

Малчдын амьжиргааг дэмжих төлөвлөгөөг 2018-2020 онд боловсруулсан бөгөөд өрх бүрийн онцлог, өрхийн гишүүдийн чадавх, амьжиргааны давуу тал зэрэгт тохируулан өрхийн гишүүдийн оролцоотойгоор хэрэгжүүлсэн юм. Малчдын амьжиргааг дэмжих төлөвлөгөө нь гурван жилийн хугацаанд амьжиргааг сэргээх бодит арга хэмжээ хэрэгжүүлэхээр цаг хугацааг нарийвчлан тодорхойлж ажилласан байна. Өрхийн амьжиргааны түвшинг сумын ядуурлын түвшинтэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөнөөр энэхүү төлөвлөгөөний үр дүнг хэмжих юм.

Энэхүү ажлын хүрээнд дараах чиглэлээр өрхүүдтэй хамтран ажиллаж, төлөвлөгдсөн санхүүжилтийг хуваарийн дагуу олгосон байна.

- Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний санхүүжилтээр ажлын байр барих, бэлэг дурсгалын дэлгүүр, үзмэрийн газар байгуулах, гар урлалын бүтээгдэхүүн хийх зэргээр 4 өрх бизнес эрхлэх, 7 өрх мал худалдан авч ашиг шимийг хүртэх зорилгоор төлөвлөгөө гарган “Оюутолгой” компанитай хамтран ажиллав.
- 2018 оноос хойш жил бүр 11 өрхөөс төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн тайлан мэдээллийг тогтмол авсан бөгөөд өрхийн амьжиргаа 10-40 хувиар өссөн байна.
- Малчдын амьжиргааг дэмжих төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд “Хөгжлийн шийдэл” ТББ-тай гэрээ байгуулан ажиллаж, өрхийн гишүүдийн бизнес саналыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.



Аж ахуйн төсөл

Амьжиргаа дэмжих төслийн хүрээнд 11 малчин өрх нэгдэн 2023 оны 11 дүгээр сард малчдын хороо бууц, худаг засварлах, газар шорооны ажил үйлчилгээ үзүүлэхээр Аж ахуйн төсөл хэрэгжүүлж эхэлсэн. Хэрэгжүүлэгч компани нь Дуутын цагаан уул



ХХК. Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай техникийн дэмжлэгийг Оюу Толгой ХХК-аас өгч, санхүүжүүлсэн. Малчдын хороо бууц засварын ажлыг сум орон нутгийн тендерт өрсөлдөж зах зээлийн зарчмаар оролцох бөгөөд зах зээл дээр хамгийн бага үнийг тогтоож үйлчилгээг боломжит хэрэглэгчдэдээ үзүүлэхээр төлөвлөж байна.

➤ 2.3 “УНДАЙН ГОЛЫН ӨВ СОЁЛ” ТӨСӨЛ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант багийн нутаг Ундайн гол дагуух өрхүүдийн ахмад настнуудад уламжлалт мал аж ахуйн мэдлэг сургаалаа залуучуудад таниулан түгээх, зөвлөх, уламжлуулах үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд нь зориулж урамшуулал олгох зорилго бүхий төслийг 2019 оны 6 дугаар сараас Ханбогд сумын “Галба” ахмадын хороотой хамтран хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Төслийн хүрээнд 2019 онд 38 ахмад давхардсан тоогоор 2236 хүүхэд залууст, 2020 онд 54 ахмад давхардсан тоогоор 1198 хүүхэд залууст, 2021 онд 55 ахмад давхардсан тоогоор 2728 хүүхэд залууст, 2022 онд давхардсан тоогоор 4564, 2023 онд 70 ахмад давхардсан тоогоор 4108 хүнд тус тус сургалт явуулсан байна.

“Ундайн голын өв соёл” төслийн хүрээнд 2023 онд давхардсан тоогоор 4108 хүнд сургалт явуулжээ. Нийтдээ 4 жилийн хугацаанд давхардсан тоогоор 14,834 иргэнийг сургалтад хамруулаад байна.

2023 оны 1 дүгээр сараас Ханбогд сумын “Галба” ахмадын хороотой 3 жил хамтран ажиллах гэрээ байгуулаад байна. Ханбогд сумын 80-аас дээш насны ахмадууд уг төсөлд хамрагдаж, ахуй амьдралдаа хэрэгжүүлж ирсэн арга ухаан, эрдэнэт мал сүрэгтэйгээ холбогдох өв уламжлалаа ирээдүй хойч үеийн залуустаа өвлүүлэн үлдээх их үйлсэд гар бие оролцож байна.



Нас өндөр болсон ахмадууд маань гэртээ үр ач нартайгаа хөлөгт тоглоом болон шагайгаар төрөл бүрийн наадгай тоглож өнгөрүүлдэг нь нэг талаараа сургалт болж, хүүхэд залууст уламжлалт тоглоом наадгайгаар тоглоход сургаж байгаа юм.

№	Огноо	Үргэлжилсэн сар	Ахмадын тоо (давхардсан)	Сургалтад хамрагдсан хүний тоо
1	2019	6-12	38 ахмад	2236 хүн
2	2020	10-12	54 ахмад	1198 хүн
3	2021	1-10	55 ахмад	2728 хүн
4	2022	1-12	69 ахмад	4564 хүн
5	2023	1-12	70 ахмад	4108 хүн
НИЙТ ДҮН		41 сар	286 ахмад	14,834 хүн

➤ 2.4 МОНИТОРИНГ

“Оюутолгой” ХХК-ийн Орон нутгийн харилцааны хэлтэс, Байгаль орчны хэлтсүүд хамтран 2011 оноос нутгийн малчдын оролцоотой байгаль орчны мониторингийн



хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Гурван талт зөвлөлийн шийдвэрийн дагуу уг хөтөлбөрийг “Мөнх ногоон Галба” ТББ өнөөг хүртэл амжилттай гүйцэтгэж байна.

2.5.1 Мониторингийн төрлүүд



“Мөнх ногоон Галба” төрийн бус байгууллага нь 2023 оны жилийн эцсийн байдлаар Ханбогд сумын 4 багийн 151 малчин өрхийн оролцоотойгоор 176 байршилд 4 төрлийн хамтын оролцоотой байгаль орчны хяналт мониторинг хийж байна.

- Усны мониторинг-116 цэг
- Бэлчээр ургамлын хяналт мониторинг-23 цэг
- Зэрлэг амьтдын хяналт мониторинг-28 цэг
- Тоосжилтын хяналт мониторинг-9 цэг

2.5.1 Зэрлэг амьтдын хяналт мониторинг

“Мөнх ногоон Галба” төрийн бус байгууллага нь зэрлэг амьтдын ажиглалт судалгааг малчдын оролцоотойгоор тогтмол зохион байгуулж байна.



2.5.2 Тоосжилтын хяналт мониторинг



“Мөнх ногоон Галба” төрийн бус байгууллага нь тоосжилтын мониторингийг MNS4585:2016 стандартын шаардлагын дагуу DUSTTRAK-8533 төхөөрөмжөөр нийт 9 байршилд сард 3 удаагийн давтамжтайгаар хийж байна. Мөн Ханбогд-Оюу толгой чиглэлийн автозам, Оюутолгой-Манлай чиглэлийн сайжруулсан шороон зам дагууд 24 цагийн тоосжилтын хэмжилт хийж байна. Тоосны мониторингийн үр дүнгээс харахад тоосжилтын хэмжээ нь хүний эрүүл мэндэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхээргүй байгаа нь ажиглагдаж байна.

2.5.3 Усны хяналт мониторинг

“Мөнх ногоон Галба” төрийн бус байгууллагын зүгээс усны хяналт мониторингийг дараах төрлүүдээр хийж байна.

- Энгийн гар худгийн түвшин хэмжилтийг 2019 оноос эхлэн 3 хоног тутамд 86 цэгт;
- Гүний хоолойн хяналтын цооногийн хэмжилтийг 2022 оноос эхлэн сар бүр тогтсон 2 цэгт;
- Булаг задгайн мониторингийг 2021 оноос хойш улиралд нэг удаа 6 цэгт;
- Гүн өрмийн худгийн түвшин хэмжилтийг 2019 оноос хойш улиралд нэг удаа 9 цэгт;
- Усны чанарын хээрийн шинжилгээг 2022 оноос хойш сар бүр;
- Усны чанарын лабораторын шинжилгээг 2019 оноос эхлэн жилд нэг удаа хийж, мэргэжлийн лабораторийн тусламжтайгаар шинжлүүлж байна.

Усны мониторингийн үр дүнгийн мэдээлэл


- Энгийн гар худгийн усны түвшин хэмжилт: 2019-2023 оны нийт хэмжилтийн дундаж утгаар усны түвшний хэлбэлзэл нь 0,01м-0,88м ба цаг агаар улирлын чанартайгаар хэлбэлзэж байна.
- Гүн өрмийн худгийн түвшин хэмжилт: 2019 оноос 10 гүний худагт хэмжилт хийж байгаа ба түвшний хэлбэлзэл нь 3-10 см байна.
- Гүний хоолойн хяналтын цооног: 2022 оноос түвшний хэлбэлзэл нь “Цооног-1” 10см хүртэл бууралттай, “Цооног 2” 1,4м хүртэл бууралттай байна. Энэ нь өвлийн саруудад ажиглагдсан ба цаг агаарын байдлаас шалтгаалан дулааны улиралд буцаад хэвийн төвшиндээ хүрсэн.
- Булаг задгайн хэмжилт: 2021 оноос хойш 4 багийн нутаг дэвсгэрийг хамарсан 6 цэгт хэмжилтийг хийж байна. Өмнөх жилүүдийн хэмжилтүүдтэй харьцуулахад 2023 онд хур тунадас муу байсан учир булаг задгайн ус ширгэсэн байдалтай, усны тэжээгдэл муутай байгаа нь ажиглагдсан.



2.5.4 Бэлчээр ургамлын хяналт мониторинг


Бэлчээрийн даацын чадавхийн судалгааг жил бүрийн 8 дугаар сард Ханбогд сумын 8 малчин өрхийн оролцоотойгоор 4 багийн 18 цэгт хийж байна. Судалгааны үр дүнг Rangeland database программл оруулж, мэдээллийн санг үүсгэсэн байна. Бэлчээрийн даацын чадавхийн судалгааны 2023 оны үр дүнгээс:

- Гавилууд баг өвөл хаврын бэлчээрийн даац 0,6 дахин хэтэрсэн
- Жавхлант баг бэлчээрийн даац хэтрээгүй
- Баян баг Өвөл хаврын бэлчээрийн даац 0.5 дахин хэтэрсэн
- Номгон баг бэлчээрийн даац хэтрээгүй



Тоорой модыг хамгаалгах чиглэлээр 2 цэгт улирал бүр 2 малчин өрхийн оролцоотойгоор хамтран мониторинг хийж байна. Модны хэмжилтийг сард 1 удаагийн хийдэг бөгөөд 2023 онд 355 бодгаль тоорой модны суулгац авсан байна. Хаягдлын сан орчмын хөрс ургамалд хүнд металлын шинжилгээг хийлээ.

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАЛ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛУУД.





“Мөнх ногоон Галба” төрийн бус байгууллагын зүгээс Ханбогд сумын 3 багийн нутаг дэвсгэрт Ухаа заг, Төлөгийн тал, Уст бага мод, Бор-овоо байршлуудад дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажлуудыг гүйцэтгэж байгаа бөгөөд дээрх байршлуудад отрын малчид мал идээшлүүлж, суулгасан тарьц суулгацыг сүйтгэх тохиолдол удаа дараа гарсан тул Ханбогд сумын сумын 2023 оны А/123 дугаар захирамжаар дээрх газруудад мал оруулах, бэлчээрлүүлэхийг хориглосон байна. Захирамжийн хүрээнд

- Ухаа заг-26,6 га
- Төлөгийн тал — 3,02 га
- Уст бага мод-4,07 га
- Бор-Овоо-3,48 га талбай буюу нийт 37,1 га талбайг хамгаалалтад авсан байна.

Ханбогд сумын Гурван талт зөвлөл





Ханбогд сумын
Гурван талт зөвлөл

